

## 6. Баруун чиглэлийн дата төв байгуулах /Өвөрхангай/

### ЗОРИЛГО

Баруун чиглэлийн дата төв байгуулагдсанаар байгалийн давтагдашгүй хүчин зүйлийн үед нийтийн мэдээллийн суурь болон төрөлжсөн мэдээллийн сан, төрийн үндсэн болон дэмжих системийн аюулгүй байдлыг хангаж, мэдээллийг нөхөн сэргээх боломж бүрдэж, Үндэсний дата төвийн найдвартай хэвийн үйл ажиллагааг урт хугацаанд бүрэн хангана.

### ХАМРАХ ХҮРЭЭ

Улсын хэмжээнд

### ХҮРЭХ ҮР ДҮН, ҮНДЭСЛЭЛ

Баруун чиглэлийн дата төв байгуулагдсанаар гадаад сүлжээний хандалт, халдлага нэмэгдэх байгаатай холбогдуулан аюулгүй байдлыг хангах боломж нэмэгдэх, төрийн байгууллагын мэдээллийг нэмж байршуулах нөөцөөр хангагдах, DDoS төрлийн халдлагаас хамгаалах төхөөрөмж нэмэгдэх, байгалийн давтагдашгүй хүчин зүйлээс үүдэлтэй аюул ослын үед хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, мэдээллийг нөхөн сэргээх боломж бүрдэнэ.

**8,500**  
сая төгрөг